



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/529

Мөрөн сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 09 дүгээр зүйлийн 9.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ний өдрийн А/135 тоот тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Бог малын мялзан” өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын арга хэмжээнд 2024 онд бойжиж буй хурга ишиг, нийт хонин сүргийг хамруулах ажлыг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулсугай

2.Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, шатах тослох материалаар ханган, ажлын явц гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Дархлаажуулалтад шаардагдах вакциныг хуваарилан, мэргэжил арга зүй удирдлагаар ханган, ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ